



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/224

Булган сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Аймгийн Засаг даргын Тамгын газрын авто зогсоолын өргөтгөл, шинэчлэл (Булган сум)”-ийн ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны  
дарга:

Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга)

Гишүүд:

Б.Ариунболд (Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Б.Баярцэнгэл (Худалдан авах ажиллагааны газрын дарга)

М.Цэрэнчимэд (Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

С.Сүхбаатар (Аймгийн Засаг даргын тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн Авто замын хяналтын улсын байцаагч)

Иргэний төлөөлөл:

М.Алтанцэцэг (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Эрдэнэтуяа (Худалдан авах ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг/холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Д.Эрдэнэбилэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010295